



37

СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 9/10

Хуурч

Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийн
ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5."в", "е", 29.1.6 "а", "л", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.7, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.3, Монгол Улсын Стандарт MNS ISO/PAS 45005:2021-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан айл өрх бүрийг бүрэн хамруулан бүх нийтийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулан гаднах хог хаягдлыг цэвэрлүүлэхийг Багийн засаг дарга нарт даалгасугай.

2.Байгууллага бүр ариутгалын бодис цэвэрлэгээний материалын нөөцийг бүрдүүлэн цэвэрлэгээ ариутгалыг 7 хоног бүрийн Баасан гарагт тогтмол хийж ариутгал хийсэн тухай тайлан зургийг Даваа гарагийн 10.00 цагт сумын Гамшгаас хамгаалах шуурхай штабын жижүүрт өгч байхыг байгууллага аж ахуйн нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

3.Долоо хоног бүрийн тайлан мэдээг баримтжуулан gsumiyasuren88@gmail.com цахим хаягаар өгч байх, захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын Гамшгаас хамгаалах шуурхай штабын дарга /Д.Алтанзориг/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.БАЯНБААТАР

0000017